

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/094/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](mailto:www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх  
Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn  
Ахлах аудитор: Ц.Отгонбаяр  
Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn  
Аудитын гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК  
Утас: 99052418 Цахим хаяг: B.Naranchimeg.POA@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**САЙХАН СУМЫН НОМГОН  
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ С.МАРТ ТАНАА**

2026.02.25 № СЭА-2026/094/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сайхан сумын Номгон тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын яамнаас 8,918.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, "Наран-Улаанбаатар ротари" төслийн байгууллагаас 19,000.0 мянган төгрөгийн ширээ сандал, шүүгээ, УИХ гишүүн Ч.Ундрамаас 14,210.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Боловсролын газраас 988.1 мянган төгрөгийн ном сурах бичиг зэрэг 43,116.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. БАТМӨНХ


## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Данс	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	1324100015 9055436 Эцсийн үлдэгдэл
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4</b>	<b>194,984,759.03</b>	<b>224,786,785.34</b>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		194,984,759.03	224,786,785.34
3121	Төгрөг		194,984,759.03	224,786,785.34
31211	Төрийн сангийн харилцах		194,984,759.03	224,786,785.34
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>6</b>	<b>52,477,158.32</b>	<b>33,574,487.14</b>
354	Хангамжийн материал		52,477,158.32	33,574,487.14
3542	Аж ахуйн материал		20,522,250.00	10,390,250.00
3547	Бусад хангамжийн материал		31,954,908.32	23,184,237.14
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>247,461,917.35</b>	<b>258,361,272.48</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>7</b>	<b>1,114,475,044.85</b>	<b>1,059,582,838.22</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>		<b>1,099,690,444.65</b>	<b>1,044,798,238.02</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,075,220,858.67	1,075,220,858.67
39202	Хуримтлагдсан элэгдэл		-243,900,422.50	-294,870,539.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл		14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		-14,562,500.00	-14,562,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		299,335,507.40	330,653,507.40
39206	Хуримтлагдсан элэгдэл		-89,422,510.19	-136,287,073.52
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		69,391,643.70	90,458,443.70
39208	Хуримтлагдсан элэгдэл		-40,720,507.59	-49,250,953.93
39214	Бусад үндсэн хөрөнгө		22,247,671.00	22,247,671.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		-9,106,004.21	-11,006,004.17
39217	Ном		16,644,208.37	17,632,328.49
393	Биет бус хөрөнгө		14,784,600.20	14,784,600.20
39301	Програм хангамж		1,768,000.00	1,768,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		-1,767,999.80	-1,767,999.80
39303	Бусад биет бус хөрөнгө		14,784,600.00	14,784,600.00
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>1,114,475,044.85</b>	<b>1,059,582,838.22</b>
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>1,361,936,962.20</b>	<b>1,317,944,110.70</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9</b>	<b>70,481,448.00</b>	<b>42,513,696.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>		<b>70,481,448.00</b>	<b>42,513,696.00</b>
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг			15,000.00
4136	Бусад өглөг		70,481,448.00	42,498,696.00
41361	Байгууллагад төлөх өглөг		70,481,448.00	42,498,696.00
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>70,481,448.00</b>	<b>42,513,696.00</b>
51	Засгийн газрын хувь оролцоо		1,291,455,514.20	1,275,430,414.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		396,512,915.71	396,512,915.71
512	Хуримтлагдсан үр дүн		198,769,467.89	182,744,368.39
5121	Өмнөх үеийн үр дүн		198,769,467.89	198,769,467.89
5122	Тайлант үеийн үр дүн			-16,025,099.50
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		696,173,130.60	696,173,130.60
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>1,291,455,514.20</b>	<b>1,275,430,414.70</b>
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>1,361,936,962.20</b>	<b>1,317,944,110.70</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>1,499,803,308.93</b>	<b>1,707,470,600.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,327,653,700.00	1,516,963,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,327,653,700.00	1,516,963,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		10,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		162,149,608.93	190,507,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		162,149,608.93	190,507,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих			
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>		<b>275,864,446.50</b>	<b>52,026,919.22</b>
120	Нийтлэг татварын бус орлого		275,864,446.50	50,516,625.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		2,236,300.00	2,434,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,061,300.00	2,434,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		175,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		270,419,388.50	43,116,120.12
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		3,208,758.00	4,966,205.10
122	Тусламжийн орлого			1,510,294.00
122001	Хандив тусламж /дотоод/			1,510,294.00
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2</b>	<b>1,775,667,755.43</b>	<b>1,759,497,519.22</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,452,971,130.71</b>	<b>1,775,522,618.72</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,407,186,810.71</b>	<b>1,726,120,586.09</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>969,550,808.00</b>	<b>1,172,677,042.95</b>
210101	Үндсэн цалин		572,340,787.00	651,989,813.29
210102	Нэмэгдэл		354,040,021.00	441,649,954.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт			33,082,818.00
210104	Урамшуулал		43,170,000.00	45,954,457.04
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>117,340,627.00</b>	<b>142,463,243.00</b>
210201	Тэтгэврийн даатгал		80,511,957.00	97,436,373.00
210202	Тэтгэмжийн даатгал		9,714,158.00	11,840,528.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		7,234,979.00	5,935,520.00
210204	Ажилгүйдлийн даатгал		2,070,279.00	5,450,185.00
210205	Эрүүл мэндийн даатгал		17,809,254.00	21,800,637.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>147,357,008.93</b>	<b>151,323,317.37</b>
210301	Гэрэл, цахилгаан		13,874,256.93	17,819,377.37
210302	Түлш, халаалт		120,384,736.00	120,397,924.00
210303	Цэвэр, бохир ус		13,098,016.00	13,106,016.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>			<b>24,048,876.28</b>
210408	Бараа материал акалсны зардал			24,048,876.28
2105	<b>Нормативт зардал</b>		<b>29,668,130.00</b>	<b>41,825,670.00</b>
210502	Хоол, хүнс		29,668,130.00	41,825,670.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>14,792,600.00</b>	<b>37,500,000.00</b>
210604	Урсгал засвар		14,792,600.00	37,500,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>11,545,979.60</b>	<b>14,182,661.74</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,138,900.00	2,434,300.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,407,079.60	11,748,361.74
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>116,931,657.18</b>	<b>142,099,774.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		35,053,564.80	26,429,448.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,866,400.00	7,405,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		74,011,692.38	108,265,126.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>45,784,320.00</b>	<b>49,402,032.63</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг		45,784,320.00	47,718,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		31,192,720.00	47,718,150.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		14,591,600.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>			<b>1,683,882.63</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг			1,683,882.63
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3</b>	<b>1,452,971,130.71</b>	<b>1,775,522,618.72</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>		<b>322,696,624.72</b>	<b>-16,025,099.50</b>
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>		<b>322,696,624.72</b>	<b>-16,025,099.50</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,502,039,608.93</b>	<b>1,711,415,194.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,236,300.00	3,944,594.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,236,300.00	2,434,300.00
122	Тусламжийн орлого		1,510,294.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,499,803,308.93	1,707,470,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,327,653,700.00	1,516,963,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	162,149,608.93	190,507,200.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,380,565,738.33</b>	<b>1,671,356,367.69</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,380,565,738.33	1,671,356,367.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,333,682,058.33	1,623,102,105.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	969,550,808.00	1,172,677,042.95
210101	Үндсэн цалин	572,340,787.00	651,989,813.29
210102	Нэмэгдэл	354,040,021.00	441,649,954.62
210103	Унаа хоолны хөнгөлөлт		33,082,818.00
210104	Урамшуулал	43,170,000.00	45,954,457.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,340,627.00	142,463,243.00
210201	Тэтгэврийн даатгал	80,511,957.00	97,436,373.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,714,158.00	11,840,528.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,234,979.00	5,935,520.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,070,279.00	5,450,185.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,809,254.00	21,800,637.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,357,008.93	151,323,317.37
210301	Гэрэл, цахилгаан	13,874,256.93	17,819,377.37
210302	Түлш, халаалт	120,384,736.00	120,397,924.00
210303	Цэвэр, бохир ус	13,098,016.00	13,106,016.00
2105	Нормативт зардал	28,568,770.00	42,958,440.00
210502	Хоол, хүнс	28,568,770.00	42,958,440.00
2106	Эд, хогшил, урсгал засварын зардал	14,792,600.00	37,500,000.00
210604	Урсгал засвар	14,792,600.00	37,500,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,191,744.60	20,916,161.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,138,900.00	2,437,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,052,844.60	18,481,861.74
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,880,499.80	32,453,263,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,014,099.80	47,951,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,866,400.00	7,312,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,883,680.00	48,254,262.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,883,680.00	46,570,380.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,292,080.00	46,570,380.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,683,882.63
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,683,882.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	121,473,870.60	40,058,826.31
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	42,784,752.00	10,256,800.00
	Дотоод эх үүсвэрээр	42,784,752.00	10,256,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-42,784,752.00	-10,256,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	78,689,118.60	29,802,026.31
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		194,984,759.03
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		224,786,785.34

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
8	2024оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	198,769,467.89	1,291,455,514.20
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга				
10	Залруулсан үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Хөрөнгө оруулалтын өсөлт, бууралт				
13	Цэвэр хөрөнгө/өмчид шууд хүлээн зөвшөөрсөн цэвэр орлого				
14	Тайлант үеийн үр дүн			-16,025,099.50	-16,025,099.50
	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	396,512,915.71	696,173,130.60	182,744,368.39	1,275,430,414.70

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	
131	Татаас, санхүүжилтийн орлого	1,917,835,600.00	1,707,470,600.00	210,365,000.00	89.0

1310	Улсын төсвөөс	1,722,402,600.00	1,516,963,400.00	205,439,200.00	88.1
131001	Урсгал	1,722,402,600.00	1,516,963,400.00	205,439,200.00	88.1
132001	Орон нутгийн төсвөөс	195,433,000.00	190,507,200.00	4,925,800.00	97.5
	<b>Бараа, үйлчилгээний орлого</b>	0.00	3,944,594.00	-3,944,594.00	
120017	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого		2,434,300.00	-2,434,300.00	
12004	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих		1,510,294.00	-1,510,294.00	
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,917,835,600.00	1,711,415,194.00	206,420,406.00	89.2
21	<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	1,917,835,600.00	1,671,356,367.69	246,479,232.31	87.1
2101	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,365,955,300.00	1,172,677,042.95	193,278,257.05	85.9
210101	Үндсэн цалин	825,884,400.00	651,989,813.29	173,894,586.71	78.9
210102	Нэмэгдэл	517,997,200.00	441,649,954.62	76,347,245.38	85.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт		33,082,818.00	-33,082,818.00	0.0
210104	Урамшуулал	22,073,700.00	45,954,457.04	-23,880,757.04	208.2
2102	<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	170,744,600.00	142,463,243.00	28,281,357.00	83.4
210201	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	116,106,300.00	97,436,373.00	18,669,927.00	83.9
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	54,638,300.00	45,026,870.00	9,611,430.00	82.4
2103	<b>Бараа, үйлчилгээний урсгал зардал</b>	332,452,000.00	307,961,819.11	24,490,180.89	92.6
2103	Тогтмол зардал	157,933,000.00	151,323,317.37	6,609,682.63	95.8
210301	Гэрэл цахилгааны зардал	18,297,000.00	17,819,377.37	477,622.63	97.4
210302	Түлш, халаалтын зардал	126,125,500.00	120,397,924.00	5,727,576.00	95.5
210303	Цэвэр, бохир усны зардал	13,510,500.00	13,106,016.00	404,484.00	97.0
2105	<b>Нормативт зардал</b>	46,067,800.00	42,958,440.00	3,109,360.00	93.3
210502	Хоол	46,067,800.00	42,958,440.00	3,109,360.00	93.3
2106	<b>Эд хогшил урсгал засварын зардал</b>	37,500,000.00	37,500,000.00	0.00	100.0
210604	Урсгал засварын зардал	37,500,000.00	37,500,000.00	0.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж</b>	22,084,300.00	20,916,161.74	1,168,138.26	94.7
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	22,084,300.00	20,916,161.74	1,168,138.26	94.7
2109	<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	68,866,900.00	55,263,900.00	13,603,000.00	80.2
210901	Бусад бараа үйлчилгээний зардал	61,544,200.00	47,951,200.00	13,593,000.00	77.9
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	7,322,700.00	7,312,700.00	10,000.00	99.9
2132	<b>Хөтөлбөр арга хэмжээний зардал</b>	48,683,700.00	48,254,262.63	429,437.37	99.1
213209	төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	48,683,700.00	46,570,380.00	2,113,320.00	95.7
0	төвлөрүүлэх шилжүүлэг		1,683,882.63	-1,683,882.63	
22	<b>Хөрөнгийн Зардал</b>		10,256,800.00		
22	Бусад хөрөнгө		10,256,800.00		
II	<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	1,917,835,600.00	1,681,613,167.69	246,479,232.31	87.7

31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		194,984,759.03		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		224,786,785.34		

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 2,113.4 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- ТАЦНС-ээр бодогдсон цалинг санхүүгийн тайлангийн Си Ти Эс программд шууд татуулахгүйгээр гараар оруулахдаа бичилтийг дүн зөрүүтэй буруу хийснээр цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ, ажиллагсадтай хийх тооцооны дансууд зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Худалдан авсан бараа материалын үнэ 2,113.4 мянган төгрөгийн төлбөрийг өөр харилцагчийн дансанд шилжүүлж өглөг, авлага үүсгэх эрсдэл бий болгосон;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалт болон УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга" стандарт болон "Толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 34,012.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 929.8 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

Дотуур байранд амьдардаг сурагчдын хоолны зарцуулалтын тооцоог хянаагүйгээс нэг хүүхдэд ногдох хоолны норматив зардлыг 929.8 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 254 дүгээр "Хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын 2 дэх "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах дунд болон ахлах ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6300 /зургаан мянга гурван зуу/, бага ангийн хүүхдийн нэг өдрийн хоолны түүхий эдийн зардлыг 6000 /зургаан мянга/ төгрөгөөр тогтоосуугай" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хоолны нормативыг мөрдөн, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх

<sup>1</sup>Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Худалдан авсан бараа материалын үнийг өөр харилцагчийн дансанд шилжүүлж өглөг, авлага үүсгэх эрсдэл бий болгосон;	1	2,113.4				2,113.4	1	2,113.4				
ТАЦНС-ээс мэдээлэл зөрүүтэй татаж програмд шивсэн	1		1									
	2	2,113.4	1		1	2,113.4	1	2,113.4				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дотуур байрны хүүхдийн хоолны зардал хэтэрсэн	1	929.8			1	929.8						
Нийт	1	929.8			1	929.8						

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИИТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			